



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар A/495

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны өрөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны А/133 дугаар тушаалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Монголын адвентист чуулган” шашны байгууллага (РД:1042548)-ын хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/138 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтын 1 дэх заалтаар Мөрөн сум 8 дугаар баг 9-46 тоотод байршилтай 6712008696 нэгж талбарын дугаартай 4217м² сууц, сургалт, ногоо тарих зориулалтаар эзэмшүүлсэн газрын зориулалтыг газрын цахим системийн зориулалтад нийцүүлэн сүм, хийд, шашны байгууллагын зориулалттай болгох, газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацаа дууссан тул өөрийнх нь хүсэлтийн дагуу газар “ashiглах” эрхийн төрлийг “эзэмших” эрхийн төрлөөр өөрчилж хүсэлт гаргасан 40 жилийн хугацаагаар сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/138 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтын 1 дэх заалтыг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч хуулийн этгээд “Монголын адвентист чуулган” шашны байгууллага (РД:1042548)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзүл)-т нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Ш.Дамдиндорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011072